


Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн
89 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Стандарт, хэмжил зүйн газар

Аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Бүтээгдэхүүн баталгаажуулалтын мэргэжилтэн

Дэс түшмэл, ТЗ-9

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй


II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Стандартчилал, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Тохирлын үнэлгээ болон салбарын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;
- 2.Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, дүн шинжилгээ хийх;
- 3.Чанарын менежментийн тогтолцооны шаардлагад үргэлжлэн нийцүүлэх, байнгын сайжруулалт хийх, баталгаажуулалтын нэгдсэн бүртгэл, статистикийг хөтлөх, тайлагнах;
- 4.Нэгжийн үйл ажиллагаанд оролцож, дэмжлэг үзүүлэх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт тохирлын үнэлгээний чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх;	Зорилт, арга хэмжээ хэрэгжсэн байна.	Г
	2.Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тохирлын үнэлгээний чиглэлээр тусгагдсан, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх;	Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ хэрэгжсэн байна.	Г
	3.Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тохирлын үнэлгээний чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх;	Зорилт, арга хэмжээ хэрэгжсэн байна.	Г
	4.Хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөөнд бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт төлөвлөсөн үр дүнд хүрч байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний санал гаргах.	Мэргэжлийн зөвлөгөө, мэдээллээр хангасан байна.	Г
	1.Итгэмжлэлийн хүрээний тодорхойлолт заагдсан бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирлын үнэлгээг холбогдох хууль тогтоомж, стандарт, схемийн дагуу гүйцэтгэх;	Бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийж, гэрчилгээжсэн байна.	


2 дугаар зорилтын хүрээнд	2.Бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирлын үнэлгээний дүгнэлт, тайланг Баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;	Хууль тогтоомж, стандартын хэрэгжилт хангагдсан байна.	Г
	3.Аюулгүйн тэмдэг хэрэглэх бүтээгдэхүүнд тохирлын үнэлгээ явуулж, дүгнэлт гаргах, шийдвэрлүүлэх;	Иргэдийн амьдралын чанар дээшилсэн байна.	Г
	4.Экспортын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд тохирлын үнэлгээ явуулж, гэрчилгээжүүлэх;	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	5.Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын дүрэм, журам, баримтжуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж шаардлагатай бол сайжруулалт хийх арга хэмжээний санал гаргах, шийдвэрлүүлэх;	Салбарын дүрэм, журам, баримтжуулсан мэдээлэлд сайжруулалт хийгдсэн байна.	Т, Г
	6.Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд сургалт зохион байгуулах.	Иргэдийн мэдлэг дээшилсэн байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Менежментийн тогтолцооны (ISO 9001, ISO 14001, ISO 22000, ISO 45001, ISO 50001, HACCP, GAP зэрэг) стандарт нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын нэгдсэн бүртгэл хөтлөх;	Нэгдсэн бүртгэл, статистик мэдээллийн тогтолцоо бүрдсэн байна.	Г
	2.Тохирлын баталгаажуулалтад хамрагдсан бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн бүртгэл хөтлөх, тайлагнах; - аюулгүй тэмдэгтэй бүтээгдэхүүн; - дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн; - органик бүтээгдэхүүн; - экспортын бүтээгдэхүүн; - үйлчилгээ.	Мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдсэн байна.	Г
	3.Чанарын менежментийн тогтолцооны шаардлагад үргэлжлэн нийцэх, байнгын сайжруулалтыг хийх;	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, хэрэглэгчийн сэтгэл ханамж дээшилсэн байна.	Г
	4.Чанарын менежментийн тогтолцоотой холбоотой дүрэм, журам баримтжуулсан	Баримтжуулсан мэдээлэлд	Г СЭШЭЭГЭВ

	мэдээллийг шинэчлэх, боловсруулах, хэрэгжүүлэх.	сайжруулалт хийгдсэн байна.	
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Нэгжийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд удирдлагатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан, ажлаа 7 хоног, сар, хагас, бүтэн жилээр төлөвлөж, тайлагнах;	Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2.Байгууллагын дүрэм, дотоод журам, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөн ажиллаж, ажлын цаг ашиглалт, хөдөлмөрийн сахилга батыг сахин ажиллах, тохирлын үнэлгээний ажлыг үнэн зөв, бодиттой, шударга байдлыг биечлэн хариуцах;	Зөрчилгүй ажилласан байна.	Г
	3.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэх;	Үүрэг даалгавар хэрэгжсэн байна.	Г
	4.Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ирсэн албан бичиг, өргөдөл гомдол, санал хүсэлтийг цаг хугацаанд нь шийдвэрлэх;	Албан бичиг, өргөдөл, гомдол хугацаандаа шийдвэрлэгдсэн байна.	Г
	5.Хариуцсан ажилтай холбоотой баримт бичгийг цэгцлэн архивын нэгж болгох;	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	6. Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээлэх;	Байгууллагын үйл ажиллагаа иргэд, олон нийтэд ил тод байна.	Г
	7.Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөж ажиллах;	Зөрчилгүй ажилласан байна.	Г
	8.Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж, авлига, ашиг сонирхлоос ангид байх;	Зөрчилгүй ажилласан байна.	Г
	9.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь тайлагнах.	Тухай бүрд тайлагнаж ажилласан байна.	Г

ШАЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол

Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй



Мэргэжил	<ul style="list-style-type: none"> - бизнес ба удирдахуй /041/; - байгалийн шинжлэх ухаан, математик, статистик /05/; - мэдээлэл, харилцаа холбооны технологиуд /06/ ; - инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж /07/. 	
Мэргэшил	Баталгаажуулалтын шинжээчийн эрх авсан байх.	
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх чадвартай байх; - хариуцсан ажил, чиг үүрэгт хамааралтай мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; - дүн шинжилгээнд тулгуурлан авах арга хэмжээ, гаргах шийдвэрийг тодорхойлох, гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, бусад хуулийг чандлан баримталж үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчлэх; - тулгамдаж буй асуудлыг судлах, удирдлагад танилцуулах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн, оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах; - хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд асуудлыг шийдвэрлэх, хариу өгөх; - холбогдох асуудлаар хуульд нийцсэн, шийдвэрлүүлэх боломжтой санал, зөвлөмж гаргах; - удирдлагыг цаг үеэ олсон, шаардлагатай мэдээлэл судалгаагаар хангаж, зөв шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дүнг хариуцах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - бусад.
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг, мэдээллээ хамт олонтой хуваалцах, түгээн дэлгэрүүлэх; - бусадтай хүндэтгэлтэй, адил тэгш, итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - бусдын санал бодлыг анхааралтай сонсож санал санаачилгыг дэмждэг байх; - аливаа асуудлыг хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэдэг байх; - аливаа сөргөлдөөн, зөрчилдөөнийг эвээр зохицуулах, гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - бусад.

	Бусад	<ul style="list-style-type: none"> - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах; - харилцааны соёлыг эрхэмлэн, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олонтой соёлч боловсон, хүндэтгэлтэй харилцах, зохих мэдээлэл, зөвлөмж өгөх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийг албан ажилдаа бүтээлчээр хэрэглэх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх ур чадвартай байх; - ажлын цагийг бүрэн, үр бүтээлтэй ашигладаг байх; - жөндөрийн тэгш байдлыг хангах; - бусад.
--	-------	---


IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга

<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект:</u> <ul style="list-style-type: none"> - зохион байгуулалтын бусад нэгж; - орон нутгийн стандарт, хэмжил зүйн хэлтсүүд; - холбогдох төрийн байгууллага болон төрийн бус байгууллагууд; - байгууллага, аж ахуйн нэгж, иргэн.
---	--

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
--	---

<u>Албан тушаал:</u> ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА  С.БАТБААТАР 20.... оны ... дугаар сарын ... -ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ <u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u>
--	--

VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН

Байгууллагын нэр: СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Шийдвэрийн огноо:
Дугаар:
 (тамга/тэмдэг)


 ДАРГА  Б.УУГАНБАЯР
 202... оны ... дугаар сарын ... -ны өдөр

